

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ МАГАДЛАН ИТГЭМЖЛҮҮЛЭХ ХҮСЭЛТ



БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Монгол улс, Улаанбаатар хот, Ерөнхий сайд Амарын гудамж,

Лагшан төв, 9 давхарт 9В тоот

Утас 70109391, факс 70104507

<http://mncea.edu.mn/>, И-мэйл: letter@mncea.edu.mn

Өргөдлийн маягт №...
(БМИҮЗ бөглөнө)

Хүсэлтийг хүлээн авсан огноо:

СУРГУУЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ:

- Сургуулийн албан ёсны нэр _____
/монгол/

/англи/
- Сургуулийн өмчийн хэлбэр: тэмдэглэнэ үү./ (Давхар тэмдэглэж болно)
 Төрийн
 Төрийн бус
 Олон улсын
 Гадаадын хөрөнгө оруулалттай
 Гадаадын салбар сургууль
 Бусад
- Сургуулийн ангилал
 Их сургууль
 Дээд сургууль
 Коллеж /политехник коллеж/
- Сургуулийг байгуулах шийдвэр гаргасан байгууллага
 Засгийн газар
 БШУЯ
шийдвэрийн дугаар _____ огноо _____
- Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар _____ дуусах огноо _____
- Эдэлбэр газрын гэрчилгээний дугаар _____ дуусах огноо _____
Гэрчилгээнд бичигдсэн эзэмшигчийн нэр _____
- Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний дугаар, эзэмшигчийн нэр _____
- Сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар _____
- Тусгай зөвшөөрөлд бичигдсэн сургалтын хөтөлбөрийн нэр, индекс

10. Сургууль нь магадлан итгэмжлэгдсэн байдал :

- анх удаа он...
 2 дахь удаа он...
 ___ удаа он...

/бичнэ үү/

11. Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрүүд: _____

12. Сургуулийн цахим хуудас: _____

13. Сургуулийн хаяг, байршил: _____

14. Сургуулийн захирал: овогтой

Утас, факс:

Цахим шуудан:

15. Сургуулийн өөрийн үнэлгээний баг байгуулсан шийдвэрийн дугаар, огноо:

-

Өөрийн үнэлгээний багийн ахлагчийн талаарх мэдээлэл:

овог, нэр _____ албан

тушаал _____

харилцах утас _____ э-шуудангийн

хаяг _____

16. Өөрийн үнэлгээний багийн гишүүд:

Нэр	Албан тушаал	Мэргэжил, мэргэшил	Холбоо барих

17. Байгууллагын нягтлан бодогчийн овог нэр, утас, цахим шуудангийн хаяг

18. Байгууллагын регистрийн дугаар

19. Сургуулийн товч танилцуулга:

20. Сургуулийн эрхэм зорилго, зорилт:

21. Эрхэм зорилго, зорилт, үйл ажиллагаа, үр дүнгийн талаар сурталчилж, мэдээлэл хүргэдэг арга хэлбэрүүд:

22. Нийгмийн хариуцлагын хэрэгжилт, үр дүнгийн чанарт үнэлгээ хийсэн байдал:

23. Чанарын баталгаажууллын бодлого, төлөвлөлт:

24. Чанарын баталгаажууллын үйл явц, хэрэгжилт:

25. Чанарын баталгаажууллын нэгжийн товч танилцуулга:

26. Дээд боловсролын сургалт эрхлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт, норм нормативыг хангасан эсэх, түүнд хийсэн өөрийн үнэлгээний товч дүгнэлт:

Хавсралт материалууд:

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбар
- Өөрийн үнэлгээний багийг томилох тухай шийдвэр
- Урт хугацааны төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд
- Чанарын гарын авлага
- Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөгдөж буй хууль, дүрэм, журмын хэрэгжилтийн биелэлт

Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан:

Сургуулийн захирал /овог нэр/
/гарын үсэг, тамга/

Магадлан итгэмжлэх өргөдлийн маягтыг хүлээн авч шийдвэрлэсэн:

БМИҮЗ-ийн Ажлын албаны захирал /Ж.Ариунболд/
/гарын үсэг, тамга/

Хүсэлтийг хүлээн авсан огноо

Хариуцсан зохицуулагч
/гарын үсэг/



**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/13

Улаанбаатар хот

**Магадлан итгэмжлүүлэх хүсэлтийн
маягыг батлах тухай**

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.6 дахь хэсэг, “Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1. дэх заалт, Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургалтын байгууллагын магадлан итгэмжлүүлэх хүсэлтийн маягыг хавсралтаар баталсугай.

2. Магадлан итгэмжлүүлэх хүсэлтийг маягтын дагуу ирүүлэхэд талуудыг мэдээллээр ханган ажиллахыг Ажлын албаны Магадлан итгэмжлэл хариуцсан ажилтан бүрт үүрэг болгосугай.

3. Магадлан итгэмжлүүлэх хүсэлттэй холбоотой мэдээлэл бүрэн, алдаагүй, байгаа эсэхэд дүн шинжилгээ хийн, гүйцэтгэлийг хянаж ажиллахыг Дотоод аудит, чанарын баталгаажуулалт хариуцсан шинжээч (Б.Соёлмаа)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Ж.АРИУНБОЛД

Боловсролын Магадлан Итгэмжлэх
Үндэсний Зөвлөлийн Ажлын албаны
захирлын 2023 оны 01 дүгээр сарын
13-ны өдрийн А/13 тоот тушаалын
хавсралт



БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ



ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ
МАГАДЛАН ИТГЭМЖЛҮҮЛЭХ ХҮСЭЛТ

Байгууллагын нэр :

УЛААНБААТАР ХОТ
20 .. ОН

Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөгдөж буй хууль, дүрэм,
журмын хэрэгжилтийн биелэлт

Дээд боловсролын сургалтын байгууллага нь тухайн шатны сургалтын байгууллагын нийтлэг шинжийг хэрхэн агуулж буй хийгээд хууль тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэр, сайдын баталсан захиргааны хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт, дүрэм, журмын хэрэгжилтийг ханган, үйл ажиллагаандаа дотоод хяналт шинжилгээ, чанарын үнэлгээ хийж хэтийн зорилго, зорилтоо тодорхойлон Монгол Улсын Боловсролын Магадлан Итгэмжлэх үндэсний зөвлөлөөр магадлан итгэмжлүүлэх, эсэх тухай дүгнэлт хийж, хүсэлт гаргахын тулд дор дурдсан хууль, дүрэм, журмын хэрэгжилтийн биелэлтийг ханган биелүүлсэн байвал зохино.

№		Урьдчилсан шалгуур	Тийм	Үгүй
1	1. Сургалтын орчин Боловсролын тухай хууль Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам	Өөрийн эзэмшлийн сургалтын байртай эсэх		
2		Дотуур байртай эсэх		
3		Дотуур байргүй бол дотуур байраар хангагдах шаардлагатай оюутнуудыг холбогдох байгууллагатай гэрээ байгуулж, байраар хангасан эсэх		
4		Нийтийн хоолны газартай эсэх		
5		Биеийн тамирын танхимтай эсэх		
6		Биеийн тамирын танхимгүй тохиолдолд холбогдох байгууллагатай гэрээ байгуулж, сургалт явуулдаг эсэх		
7		Дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бичиг баримт хадгалах зориулалтын өрөөтэй эсэх		
8		Архив хариуцсан мэргэжлийн ажилтантай эсэх		
9		"Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага"-ыг хангасан номын сантай эсэх		
10		Мэргэжлийн номын санчтай эсэх		
11		Номын сан нь электрон каталоги бүхий мэдээллийн баазтай, цахим хэлбэрээр ашиглах номын фондтой эсэх		
12		Сургуулийн удирдлагын мэдээллийн системийн байнга ашигладаг программ хангамжтай эсэх		
13		Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, багш, оюутныг нэвтрүүлэх зориулалтын шат, ариун цэврийн өрөөтэй эсэх		
14	2. Багш Боловсролын тухай хууль Дээд боловсролын тухай хууль Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам БШУ-ны сайдын 2014 оны Магистр докторын сургалт эрхлэх нийтлэг журам Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль	Хөдөлмөрийн гэрээг байгуулдаг эсэх		
15		Багшийн ажлын ачаалал тооцох журам хэвшсэн эсэх		
16		Нийт багш нарын 75-аас доошгүй хувь нь үндсэн багш эсэх		
17		Нэг багш мэргэжлийн дагуу улиралд 3-аас илүүгүй хичээл заадаг эсэх		
18		Дээд сургуулийн үндсэн багшийн 15-аас доошгүй хувь нь докторын зэрэгтэй эсэх		
19		Багш магистраас доошгүй зэрэгтэй эсэх		
20		Магистрын сургалт явуулдаг бол магистрын хөтөлбөрт хамаарах хичээлийг доктор зэрэгтэй багш хөтлөн явуулдаг эсэх		
21		Их сургуулийн үндсэн багш нарын 30-аас доошгүй хувь нь докторын зэрэгтэй эсэх		
22		Багш заах арга зүй эзэмшсэн, багшлах эрхийн үнэмлэхтэй эсэх		
23		Магистрын ажлын удирдагч нь докторын зэрэгтэй, их, дээд сургууль эсхүл эрдэм шинжилгээний байгууллагад 3 аас доошгүй жил ажилласан туршлагатай идэвхтэй судлаач эсэх		
24	Докторын ажлын удирдагч нь тухайн мэргэжлийн			

		чиглэлээрээ сүүлийн 3 жилд 1-с цөөнгүй эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн, идэвхтэй судлаач эсэх		
25		Багшийн хөгжлийн төвтэй, Багшийн хөгжлийг дэмжих санхүүжилтийг баталгаажуулсан эсэх		
26	3. Суралцагчид Дээд боловсролын тухай хууль Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам БСШУС-ын А/261 "Дээд боловсролын салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэний сурч, боловсрох нөхцөлийг хангах тухай" тушаал	Жил бүр оюутны элсэлтийн журмыг шинэчлэн баталгаажуулдаг эсэх		
27		Оюутны өөрийн удирдлагын байгууллагатай эсэх		
28		Оюутны соёл, спортын арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг, халдварт өвчин, нийгмийн хорт зуршлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр лекц, семинар, бусад арга хэмжээ улирал бүр тогтмолжсон байна. Мэргэжлийн чиглэлийн дагуу мэргэшүүлэх секц, дугуйлан хичээллүүлдэг эсэх		
29		Төгсөгчдийг ажилд зуучлах нэгжтэй эсвэл ажилтантай эсэх		
30		Төгсөгчдийн ажлын байрны судалгааг гаргаж, төгссөнөөс хойш 6 сарын болон нэг жилийн дотор ажлын байраар хэрхэн хангагдсан тухай судалгаа хийдэг эсэх		
31		Боловсролын баримт бичгийг зохих журмын дагуу олгодог эсэх		
32		Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч хариуцсан мэргэжилтэнтэй эсэх		
33		Оюутанд чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулсан санхүүжилтийг баталж хэрэгжүүлдэг эсэх		
34	4. Сургалтын хөтөлбөр Дээд боловсролын тухай хууль Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам	Сургалтын чанарын баталгаажуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээний орон тооны нэгжтэй эсвэл хариуцсан ажилтантай эсэх		
35		Мэргэжлийн чиглэл/индексстэй нийцсэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй эсэх		
36		Журамд нийцсэн үнэлгээний тогтолцоотой эсэх		
37		Жирэмсэн, эрүүл мэндийн шалтгаантай суралцагчдад сургалтын олон төрлийн хэлбэрээр суралцах боломжоор хангасан эсэх		
38		Сургалтад тусгай болон албан хэрэгцээний зориулалтын хэрэглээний програм хангамж ашигладаг эсэх		
39		Сургалтын материал, цахим хэрэглэгдэхүүн, хичээлийн цахим сан үүсгэсэн эсэх		
40		5. Эрдэм шинжилгээ Боловсролын тухай хууль Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам БШУ-ны сайдын 2014 оны Магистр докторын сургалт эрхлэх нийтлэг журам	Шинжлэх ухааны тодорхой чиглэлээр судалгаа шинжилгээ явуулдаг, эрдэм шинжилгээний асуудал хариуцсан нэгжтэй эсэх	
41	Магистр, докторын хөтөлбөрийг хариуцсан нэгжтэй эсэх			
42	Нийт багш нарын 70-аас доошгүй хувь нь эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэдэг эсэх			
43	Шинжлэх ухааны холбогдох чиглэлээр төрөлжсөн лабораторитой эсэх			
44	Нийт эрдэм шинжилгээний бүтээлд гадаад орны эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлүүлсэн болон оюуны өмчийн гэрчилгээ, патент авсан бүтээлийн эзлэх хувь 3-аас доошгүй хувь эзэлдэг эсэх			